



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2007 оны 9 сарын 27 өдөр

Дугаар 335


Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам”, “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”, “Өндөр хөгжилтэй орны их сургуульд Засгийн газрын тэтгэлгээр хүн суралцуулах асуудлаар санал боловсруулах зөвлөл”-ийн 2007 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэл, Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 292 дугаар тушаалын Баяр овогтой Энхмаатай холбогдолтой хэсгийн “Англи улсын Лондонгийн Оксфорд коллежийн” гэснийг “Англи улсын Лондонгийн Худалдааны сургуулийн” гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 148 дугаар тушаалын Ичинхорлоо овогтой Жаргалзаяабямбатай холбогдолтой хэсгийн “АНУ-ын Вирджиния Олон улсын их сургуулийн” гэснийг “Англи улсын Лондонгийн Оксфорд коллежийн” гэж тус тус өөрчилсүгэй.




Ө.ЭНХТҮВШИН